



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 06 сарын 09 өдөр

Дугаар А/251

Мандалговь

“Илүүдэл жингүй эртэч Монгол” аянд
зардал гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5, 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.6 дэх заалт, Засаг даргын 2022 оны А/251 дүгээр захирамжаар батлагдсан “Урамшууллын жишиг тогтоох журам”-ын 2.2 дахь заалт, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 09 дүгээр хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Ерөнхий сайдын санаачилгаар Монгол орон даяар “Илүүдэл жингүй эртэч Монгол 2022”-г үргэлжлүүлэн нийтийн биеийн тамирыг хөгжүүлж, дасгал хөдөлгөөний цахим хичээл бэлтгэхэд 5,000,000 (таван сая) төгрөгийг зарцуулсугай.

2. Захирамжийн хэрэгжилтийг хангаж, цахим хичээлийг иргэд олон нийтэд хүргэх ажлыг зохион байгуулахыг Төрийн захиргаа удирдлагын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Н.Түвшинжаргал), Нийгмийн бодлогын хэлтсийн ахлах мэргэжилтэн (М.Болор-Эрдэнэ) нарт тус тус даалгасугай.

3. Зардалд шаардагдах 5,000,000 (Таван сая) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Доржбат), нягтлан бодогч (Н.Энхмарт) нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

4822100721